



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 18 өдөр

Дугаар A/395

Номгон

Тээврийн хэрэгсэл хүлээнцэх ажлын  
хэсэг байгуулах тухай

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын үед Баянхонгор сумын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн ариутгал халдвартгуйжүүлэлтийг тогтмол хийхэд зориулалтын тээврийн хэрэгсэл шаардлагатай байгаа тул Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2."б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Мал угаалгын автомашиныг "Баянхонгор тохижилт үйлчилгээ" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: А.Дорж- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Зам, тээврийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Т.Отгонбаатар- "Баянхонгор тохижилт үйлчилгээ" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал

Ж.Цогтбаяр- "Баянхонгор тохижилт үйлчилгээ" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын менежер

Нарийн бичгийн дарга: Л.Доржханд- Орон нутгийн өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Тээврийн хэрэгслийг холбогдох бичиг баримтыг үндэслэн 2021 оны 07 дугаар сарын 30-ны дотор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн, балансаас балансад шилжүүлэх шийдвэр гаргуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

621010991

2.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

